



**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ**



МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТ. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА MNS 6541:2015

Салбарын нэр: Хөдөө аж ахуй

Мэргэжлийн нэр: Эрчимжсэн гахайн аж ахуй

БОУСА-ийн хөтөлбөрийн индекс:

Монголын мэргэшлийн үндэсний хүрээний түвшин: VI

**УЛААНБААТАР ХОТ
2019 он**

Боловсруулсан багийн гишүүд:

- | | | |
|---|----------------|---|
| 1 | С.Алтанхуяг | Хувиараа гахайн аж ахуй эрхлэгч |
| 2 | Ц.Баттулга | Хувиараа гахайн аж ахуй эрхлэгч |
| 3 | Д.Жанчивдорж | Монголын гахайн аж ахуй эрхлэгчдийн холбооны удирдах зөвлөлийн гишүүн |
| 4 | З.Заяахүү | “Зургаан хошуу” ХХК-ийн менежер |
| 5 | Х.Лхамсүрэн | Хүнс, Хөдөө Аж ахуйн ассоциацийн мэргэжилтэн |
| 6 | Б.Отгонбаяр | “Чез Энд Эл” ХХК-ийн захирал |
| 7 | Ц.Отгонтуул | “Алтандорж” ХХК-ийн захирал |
| 8 | З.Оюунтунгалаг | “Фрэш Пок” ХХК-ийн гүйцэтгэх захирал |
| 9 | Т.Түмэннаст | Хувиараа гахайн аж ахуй эрхлэгч |

Хянасан: ХНХЯ болон хөдөө аж ахуйн салбарын экспертүүдийн төлөөлөл

- | | | |
|---|---------------|---|
| 1 | Д.Адилбиш | ХНХЯ-ны МБСБХЗГ-ын ахлах мэргэжилтэн |
| 2 | Н.Батсуурь | Хөдөө аж ахуйн их сургуулийн зөвлөх |
| 3 | Д.Жанцанхорол | “Монголын ХАА-н дэвшил холбоо” ТББ-ын гүйцэтгэх захирал |
| 4 | Б.Оргил | “Фрэш Пок” ХХК-ийн захирал |
| 5 | С.Дүгэрсүрэн | “Биологи, биотехнологийн мэдээлэл сургалтын төв” ТББ-ын гүйцэтгэх захирал |
| 6 | П.Мягмарсүрэн | Мал эмнэлгийн хүрээлэнгийн эрхлэгч |
| 7 | А.Баянзул | Хөдөө аж ахуйн их сургуулийн багш |
| 8 | Н.Хишигжаргал | Хүнсний технологийн дээд сургуулийн багш |

DACUM чиглүүлэгч:

- | | | |
|---|----------|--|
| 1 | О.Саруул | Говийн бүсийн арга зүйн төвийн менежер |
|---|----------|--|

Зөвлөхүүд :

- | | | |
|---|-------------|---|
| 1 | Д.Энхбаатар | ЧССҮ-ний Үндэсний зөвлөх |
| 2 | Ц.Ганчимэг | АХБ-ны Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ЧССҮ-ний мэргэжилтэн |
| 3 | Г.Батчимэг | ЧССҮ-ний зөвлөх |

АГУУЛГА		Хуудас
	Баталгаажилтын хэсэг	2
	Өмнөх үг	4
1	Зорилго	5
2	Хамрах хүрээ	5
3	Норматив ишлэл	5
4	Нэр томъёо, тодорхойлолт	6
5	Мэргэжлийн боловсрол, сургалтын агуулгад тавигдах шаардлага	8
	5.1 Сургалтын агуулга	8
	5.2 Сургалтын хугацаа	29
6	Суралцах хэлбэр	29
7	Сургалтын үнэлгээнд тавигдах шаардлага	30
8	Эрчимжсэн гахайн аж ахуйн фермер мэргэжлээр элсэгчдэд тавигдах шаардлага	30
9	Багшид тавигдах шаардлага	30
10	Сургалтын орчинд тавигдах шаардлага	31
11	Сургалтын тоног төхөөрөмж, багаж, хэрэгслийн жагсаалт	32
12	Номын сан, мэдээллийн хангамжид тавигдах шаардлага	39
13	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага	39
14	Стандартад хэрэглэсэн товчилсон үгийн тайлбар	39

ӨМНӨХ ҮГ

Хөдөө аж ахуй, барилга, зам тээврийн салбарт мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэх, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хэрэгжүүлж буй L3243-MON “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд “Эрчимжсэн гахайн аж ахуйн фермер” мэргэжлээр Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлагыг боловсруулав.

Энэхүү “Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлага”-ыг эрчимжсэн гахайн аж ахуйн фермерийн мэргэжилтэй ажилтнууд болон ажил олгогчид, чадамжид суурилсан сургалт, үнэлгээний олон улсын зөвлөх, үндэсний зөвлөх, салбарын багш нарын төлөөллийг оролцуулан DACUM арга зүйгээр боловсруулсан ажил мэргэжлийн лавлахад үндэслэн ажилбар, үүрэг нэг бүрээр чадамжийн дүн шинжилгээ хийж боловсруулсан болно.

Мэргэжлийн боловсрол, сургалт нь төр, хувийн хэвшлийн бодит түншлэл, шинэ технологи, шилдэг сургалтын арга зүйд тулгуурлан хөгжиж, өндөр ур чадвартай мэргэжилтэй ажилтнууд төрөн гарч, үйлдвэрлэгч, бүтээгч улс болж, хөгжих болтугай.

1. Зорилго

Энэхүү стандартын зорилго нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн шаардлагыг хангахуйц, мэргэшлийн түвшний тогтолцоотой уялдсан уян хатан сургалтыг “Эрчимжсэн гахайн аж ахуйн фермер” мэргэжлээр зохион байгуулах мэргэжлийн боловсрол, сургалтын агуулга, орчин, багшийн мэргэшил, үнэлгээнд тавигдах үндсэн шаардлагыг тогтооход оршино.

2. Хамрах хүрээ

Энэхүү стандартыг “Эрчимжсэн гахайн аж ахуйн фермер” мэргэжлээр мэргэжлийн боловсрол, сургалт эрхлэн явуулж буй өмчийн бүх хэлбэрийн байгууллага, нийгмийн түнш, багш, суралцагч, судлаач, мэргэжлийн боловсрол, сургалтын асуудлаарх төрийн удирдлага, аргазүй, хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагууд хэрэглэнэ.

3. Норматив ишлэл

Энэхүү стандартад олон улсын болон үндэсний стандарт, баримт бичгийг иш татаж хэрэглэсэн болно. Эдгээр баримт бичгүүдэд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны хэвлэлийг хэрэглэнэ. Үүнд:

- 3.1** MNS 1-1:2006 Монгол улсын стандартчиллын тогтолцоо. 1-р хэсэг
- 3.2** MNS 1-2:2006 Монгол улсын стандартчиллын тогтолцоо. 2-р хэсэг
- 3.3** MNS 5742:2007 Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага
- 3.4** MNS 5566:2005 Аж ахуйн нэгж байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм
- 3.5** MNS 4990:2015 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага
- 3.6** MNS 5869:2008 Оюутны дотуур байрны үйлчилгээ. Ерөнхий шаардлага
- 3.7** БНБД-II-66-88 “Сургалт хүмүүжлийн барилгын зураг төсөл зохиох нэгдсэн норм”
- 3.8** БНБД 21-01-02 Барилга, байгууламжийн галын аюулгүй байдал
- 3.9** Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль
- 3.10** Гахайн аж ахуйд мөрдөх мал эмнэлэг, ариун цэврийн нийтлэг журам
- 3.11** Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль, дүрэм, журам
- 3.12** MNS 0167-2012 Гахайны хэсэглэж, ангилсан мах. Ерөнхий шаардлага
- 3.13** MNS 5998-2009 Мал нядлах үйлдвэр. Аюулын дүн шинжилгээ ба эгзгийг хянах цэгийн (НАССР)тогтолцооны загвар
- 3.14** YAMAT-08 Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт
- 3.15** Ажил мэргэжлийн лавлах толь, Улаанбаатар, 2014

4. Нэр томъёо, тодорхойлолт

4.1

албан боловсрол

боловсролын албан ёсны байгууллагаар дамжуулж, суралцагчийн ерөнхий болон мэргэжлийн зохих түвшний боловсрол эзэмших хэрэгцээг хангадаг боловсролын зохион байгуулагдсан үйл ажиллагааг;

4.2

мэргэжил

тодорхой ажил, хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадлын цогцыг;

4.3

мэргэшил

тодорхой мэргэжлийн хүрээнд ажил гүйцэтгэхэд шаардагдах мэргэжлийн мэдлэг, чадвар, дадлын түвшинг;

4.4

мэргэжлийн боловсрол

тодорхой мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэх хэрэгцээнд нийцүүлж зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшлийг;

4.5

техникийн боловсрол

техник, технологийн үйл ажиллагааг гүйцэтгэх, удирдах хэрэгцээнд нийцүүлж зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн үйлдвэрлэл, техник, технологийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшлийг;

4.6

мэргэжлийн суурь чадвар

нийгмийн харилцаанд оролцоход шаардагдах мэдлэг, чадвар, төлөвшлийг;

4.7

мэргэшлийн түвшин

ажилтны эзэмших мэдлэг, чадвар, гүйцэтгэх ажил үүргийн төлөвшил, хариуцлага, хандлагын хүрээг стандартаар тодорхойлсон мэргэшлийн шатлалыг;

4.8

чадамжид суурилсан сургалт

мэргэжлийн боловсрол, сургалтаар ажлын байранд тухайн ажлыг ажил мэргэжлийн стандартын дагуу гүйцэтгэхийн тулд эзэмших шаардлагатай мэдлэг, ур чадвар, хандлагыг олгох, төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт;

4.9

чадамжид суурилсан үнэлгээ

суралцагч ажил, үүргийг мэргэжлийн дэлгэрэнгүй тодорхойлолтод нийцүүлэн зөв, нямбай хийж гүйцэтгэж байгаа эсэхийг чадамжийн нэгжийн хүрээнд боловсруулсан гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн дагуу нотолгоонд суурилан үнэлгээ хийж, баримтжуулах үйл явц;

4.10

чадамж

хөдөлмөрийн орчинд ажил олгогчийн зүгээс тавигдах мэргэжлийн шаардлагыг биелүүлэх түвшинд эзэмшсэн байвал зохих мэдлэг, чадвар, дадал, хөдөлмөрийн соёлын төлөвшлийг;

4.11

чадамжийн нэгж

үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгддөг гүйцэтгэлийн үнэлэмжийн хамгийн бага нэгж бөгөөд ихэвчлэн үр дүнгээр хэмжигддэг. Тодорхой ажил үүргийг гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, ур чадвар, хандлагыг;

4.12

чадамжийн элемент

чадамжийн нэгжийн дагуу гүйцэтгэх ёстой ажлын гол хэсгүүд буюу ажилбарыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай гол үе шатууд. Элементүүд нь тодорхой ажлыг гүйцэтгэхэд хэрэгцээтэй үйлдлүүдийг тодорхойлдог;

4.13

гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт

чадамжийн нэгж болон элементүүдийг тавигдсан стандартын дагуу гүйцэтгэх шалгуур;

4.14

үнэлгээний төлөвлөгөө

зорилтот бүлгийг ямар чадамжийн нэгжийн шалгуур үзүүлэлтийн дагуу хэзээ, хаана, хэрхэн яаж үнэлэхийг төлөвлөсөн баримт бичиг;

4.15

чадамжийн нэгжийн үнэлгээ

тухайн хувь хүн чадамжийн стандартыг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд нотлох материал, мэдээлэл цуглуулж холбогдох үнэлэлт, дүгнэлт гаргах үйл явц;

4.16

чадамжийн багц

ажилтан мэргэжлийн дэлгэрэнгүй тодорхойлолтод нийцүүлж, хөдөлмөрийн чиг үүргийн чанартай гүйцэтгэлийг хангахад шаардагдах мэдлэг, чадвар, туршлага харилцааны багц;

4.17

багц цаг

дээд болон мэргэжлийн боловсролын агуулгын багтаамжийг хэмжих нэгжийг.

5. Мэргэжлийн боловсрол, сургалтын агуулгад тавих шаардлага

5.1 Сургалтын агуулга

- 5.1.1** Мэргэжлийн боловсрол, сургалтын агуулга нь “Эрчимжсэн гахайн аж ахуйн фермер” мэргэжилд хамаарах чадамжийн нэгжүүдээс бүрдэнэ. Чадамжийн нэгжийг “Эрчимжсэн гахайн аж ахуйн фермер” мэргэжлийн ажил мэргэжлийн тодорхойлолтод (лавлах) тусгагдсан мэргэжлийн үүрэг, ажилбаруудад тулгуурлан боловсруулсан болно.
- 5.1.2** Ажил мэргэжлийн үүрэг, ажилбаруудыг DACUM (ажил мэргэжлийн дүн шинжилгээ хийх) аргаар тодорхойлж, ажил олгогч, мэргэжлийн холбоодтой хамтран боловсруулсан.
- 5.1.3** Ажил мэргэжлийн дүн шинжилгээнээс “Эрчимжсэн гахайн аж ахуйн фермер” мэргэжлийн чадамжийн нэгжийн жагсаалтыг тодорхойлж гаргасан. Уг чадамжийн нэгжийн жагсаалтад ороогүй “Эрчимжсэн гахайн аж ахуйн фермер” мэргэжлийн ерөнхий суурь хэсэг болон мэргэжлийн үндсэн ойлголт, онолын мэдлэгийг багш сургалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

А хавсралт: А.1-р маягт

ЧАДАМЖИЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

д/д	Сургалтын агуулга	Чадамжийн нэгжийн нэр	Чадамжийн нэгжийн код
1	Мэргэжлийн суурь	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах	АН 6320-13-01
2		Тэжээлийн нөөц бүрдүүлэх	АН 6320-13-02
3		Үржлийн ажлыг зохион байгуулах	АН 6320-13-03
4		Гахайн сүргийг маллах	АН 6320-13-04
5		Гахайн эрүүл мэндийг хамгаалах	АН 6320-13-05
6	Мэргэшүүлэх	Бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх	АН 6320-13-06
7		Аж ахуй эрхлэх	АН 6320-13-07

5.1.4 “Эрчимжсэн гахайн аж ахуйн фермер” мэргэжил нь Монголын мэргэшлийн үндэсний хүрээний VI түвшинд хамаарах бөгөөд хамаарах чадамжийн нэгж бүрийг эзэмших шаардлагатай.

5.1.5 Энэхүү стандартын А хавсралт: А.1-р маягтад дурьдах шаардлагатай “Эрчимжсэн гахайн аж ахуйн фермер” Монголын мэргэшлийн үндэсний

хүрээний VI түвшинд харгалзуулах чадамжийн нэгжүүд нь 5.1.3-т зааснаар, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд нь А хавсралт: А.3-р маягтад заасны дагуу тодорхойлогдоно.

- 5.1.6** Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага, төлөвшлийн жагсаалтуудыг А хавсралт, А.2-р маягтын дагуу дараах байдлаар боловсруулсан.
- 5.1.7** Чадамжийн нэгж нь чадамжийн элементүүдээс бүрдэнэ. Чадамжийн элементийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг А хавсралтын А.3-р маягтын дагуу боловсруулсан. (А хавсралтын А.2, А.3-р маягыг нэгтгэн чадамжийн нэгж бүрээр боловсруулсан.)

Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага

ТҮВШИН VI
Чадамжийн нэгж: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах
Чадамжийн нэгжийн код:
<p>Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага</p> <p>Эзэмшвэл зохих мэдлэг</p> <ul style="list-style-type: none"> • Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, дүрэм журам • Хөдөлмөр хамгааллын практик хэрэглээ • Аюулгүй ажиллагааны зааварчилгаанууд • Хувийн хамгаалах хэрэгслийн төрлүүд, тэдгээрийн ашиглалт • Ажлын байран дээрх хамгаалалтын хаалт хашилт, зурагт хуудас, тэдгээрийн төрөл • ХАБЭА-н шаардлага, стандарт мөрдөх • Аюул, эрсдэлийг тодорхойлох, хянах мэдээлэх • Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн үзүүлэлтүүд • Гахайн аж ахуй эрхлэх аюулгүй байдал, эрүүл ахуйн дэг журам <p>Эзэмшвэл зохих ур чадвар</p> <ul style="list-style-type: none"> • Хувийн ариун цэврийг сахих • Аюул, эрсдэлийг тодорхойлж, хянах • Мэдээлэл харилцааны бусад • Ажлын байрыг бэлтгэх • Зориулалтын дагуу багаж хэрэгслийг ашиглах • Онцгой байдлын үед авах арга хэмжээг хэрэгжүүлэх • Анхны тусламж үзүүлэх • Хувийн хамгаалах хэрэгслийг зөв зохистой бүрэн ашиглах • ХАБЭА-н шаардлага стандарт ажлын байранд бүрэн ашиглах • Хамтран ажиллагчдад зөв мэдээлэл дамжуулах чадвар • Гадна дотны бүх харилцагчтайгаа хүндэтгэлтэй, зөв боловсон, шударга харилцах <p>Хөдөлмөр эрхлэхэд зайлшгүй шаардлагатай хандлага, төлөвшил</p> <ul style="list-style-type: none"> • Өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангах • Эрүүл ахуйг хангах • Зөв аюулгүй ажиллах арга барил хандлага эзэмших • Хувийн ариун цэврийг сахих • Суралцах соёл • Хөдөлмөрийн сахилгатай • Нягт нямбай, цэвэрч • Мэргэжилдээ сонирхолтой • Идэвхи санаачилгатай • Хариуцлагатай • Хувийн зохион байгуулалттай

Элемент, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт

ЭЛЕМЕНТ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
ЧЭ 1. ХАБЭА-н үндсэн ойлголт ба хууль эрх зүйн орчин	ГШҮ 1.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн бүтэц, агуулгатай танилцах
	ГШҮ 1.2 ХАБЭА-д холбогдох эрх зүйн бусад баримт бичигтэй танилцах
	ГШҮ 1.3 ХАБЭА-н хууль тогтоомж болон бусад шаардлагыг зөрчих, түүний үр дагавартай танилцах.
	ГШҮ 1.4. Хамгаалах техник, хувийн ба тусгай хамгаалах хэрэгсэлтэй танилцах
	ГШҮ 1.5 ХАБЭА-н сургалт, зааварчилгаа, аюулгүйн тэмдэг тэмдэглээгээтэй танилцах
ЧЭ 2. Ажлын байрыг зөв зохион байгуулах	ГШҮ 2.1 Ажлын байран дахь осол, гал түймэр, онцгой байдлын үед сахих дүрэм журмыг байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, бодлогод уялдуулан дагаж мөрдөх
	ГШҮ 2.2 Ажлын байрны шаардлага стандарт хангаж ажиллах.
	ГШҮ 2.3 Аюулгүй ажиллагааны шаардлагын дагуу багаж хэрэгслийг зориулалтын дагуу ашиглах
ЧЭ 3. Ажлын байрны аюулыг илрүүлэх болон эрсдэлийн үнэлгээнд оролцох	ГШҮ 3.1 Ажлын байрны аюулыг тодорхойлох, тохиромжтой арга барил сонгоход оролцох.
	ГШҮ 3.2 Аюулыг илрүүлж байгаа ажилтанг тусламж, мэдээллээр хангах
	ГШҮ 3.3 Ажлын байрны эрсдэлийн үнэлгээний тохиромжтой арга сонгоход оролцох.
	ГШҮ 3.4 Эрсдэлийн үнэлгээ хийж байгаа ажилтанг тусламж, мэдээллээр хангах
ЧЭ 4. Хөдөлмөрийн, аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах	ГШҮ 4.1 Хувийн хамгаалах хэрэгслийг байгууллагын заавар чиглэл, дүрэм журамд нийцүүлэн ашиглах
	ГШҮ 4.2 Ажлын байранд тавигдах шаардлагын дагуу хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын хувийн хэргийг бөглөх
	ГШҮ 4.3 Онцгой байдалтай холбоотой дасгал, сургуулилтын үед баримтлах дүрэм журмыг байгууллагын тогтсон заавар чиглэл, дүрэм журамд нийцүүлэн зүй зохистой дагаж мөрдөх
ЧЭ 5. Шаардлагатай нөхцөлд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх	ГШҮ 5.1 Ажлын байран дахь яаралтай тусламжийн үед туслалцаа үзүүлэхтэй холбоотой дүрэм журмыг байгууллагын тогтсон дэг журамд нийцүүлэн тодорхойлох
	ГШҮ 5.2 Осол гэмтлийн үед анхны тусламж үзүүлэх арга барил, аргачлалыг судлах
	ГШҮ 5.3 Дасгал сургуулилтын явцад зөв аргаар цаг алдалгүй анхны тусламж үзүүлэх

Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага

ТҮВШИН VI
Чадамжийн нэгж: Тэжээлийн нөөц бүрдүүлэх
Чадамжийн нэгжийн код:
Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага Эзэмшвэл зохих мэдлэг <ul style="list-style-type: none">• Бүрэн найрлагат балансжуулсан тэжээлийн жор, орцын чанарын параметрууд• Тэжээлийн түүхий эдийн ангилал, онцлог, химийн найрлага, тэжээллэг чанар, хадгалах нөхцөл, шаардлага• ХАБЭА-н шаардлагууд• Гахайн тэжээлийн шимт бодисын хэрэгцээ нас, хүйс, төрөл тус бүрээр• Аж ахуйн худалдан авах ажиллагааны журам• Тэжээлийн үйлдвэрийн машин, тоног төхөөрөмжийг ажиллуулах арга технологи• Тэжээгүүрийн систем Эзэмшвэл зохих ур чадвар <ul style="list-style-type: none">• Бусадтай харилцах• Тоо бодох, унших, бичих• Тэжээлийн нөөцийн чанарыг үнэлэх• Тэжээлийн цехийг оновчтой зохион байгуулах• Тэжээл, тэжээлийн түүхий эдийн орлого, зарцуулалтыг бүртгэх, хяналт тавих• Аюулыг илрүүлж, аюулгүй ажиллагааны хяналт тавих• Аж ахуйн бүртгэлийн журам• Үндэсний хэмжээний хамааралтай хууль тогтоомж, ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдал, машин, тоног төхөөрөмжид хяналт тавих• Гал унтраах төхөөрөмжийг ажиллуулах• Ажлын ур чадварын зааварчилгаа өгөх Хөдөлмөр эрхлэхэд зайлшгүй шаардлагатай хандлага, төлөвшил <ul style="list-style-type: none">• Нягт нямбай• Гүйцэтгэл сайтай ажиллах• Хариуцлагатай• Багаар ажиллах• ХАБЭА-н шаардлагыг хангаж ажиллах

Элемент, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт

ЭЛЕМЕНТ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
ЧЭ 1. Тэжээлийн хэрэгцээ тодорхойлох	ГШҮ 1.1 Гахайн тэжээллэгт тохирох түүхий эдүүдийн эх үүсвэрийг тогтоох
	ГШҮ 1.2 Аж ахуйн ашиглах боломжтой түүхий эдийн нэр төрлийг тогтоох
	ГШҮ 1.3 Аж ахуйн тэжээлийн жор боловсруулах
	ГШҮ 1.4 Үржлийн бодонгийн тэжээлийн хэрэгцээг тодорхойлох
	ГШҮ 1.5 Мэгжний тэжээлийн хэрэгцээг төрөл тус бүрээр тогтоох
	ГШҮ 1.6 Торойн төрөл тус бүрээр тэжээлийн хэрэгцээг тодорхойлох
	ГШҮ 1.7 Өсвөр болон бордооны гахайн тэжээлийн хэрэгцээг тооцоолох
ЧЭ 2. Бүрэн найрлагат тэжээл үйлдвэрлэх	ГШҮ 2.1 Тэжээлийн үйлдвэрийн байрыг цэгцлэх
	ГШҮ 2.2 Тэжээл үйлдвэрлэх тоног төхөөрөмжийг бэлдэх
	ГШҮ 2.3 Тэжээлийн түүхий эдүүдийг бэлдэх
	ГШҮ 2.4 Тэжээлийг жорын дагуу холих
	ГШҮ 2.5 Холисон тэжээлийг савлах
	ГШҮ 2.6 Үйлдвэрлэлийн ажиллагааг дуусгах
ЧЭ 3. Тэжээлийн нөөцийг хадгалах	ГШҮ 3.1 Тэжээлийн нөөц хадгалах агуулахыг бэлтгэх
	ГШҮ 3.2 Тэжээлийн нөөцийг эргүүлэх, шилжүүлэн байршуулах
	ГШҮ 3.3 Тэжээлийн нөөцөөс дээжийг хуваарийн дагуу лабораторт шинжлүүлэх
	ГШҮ 3.4 Шаардлагатай хөдөлмөр хамгааллын хэрэгсэл ашиглаж байгаад хяналт тавих
	ГШҮ 3.5 ХАБЭА шаардлагын биелэлтэд хяналт тавих
	ГШҮ 3.6 Тэжээлийн нөөцийн зарцуулалтад хяналт тавих
ЧЭ 4. Технологийн зааврыг мөрдүүлэх	ГШҮ 4.1 Технологийн заавар боловсруулах
	ГШҮ 4.2 Технологи ажиллагааг хийлгэж үзүүлэх
	ГШҮ 4.3 Технологи ажиллагааг дагуулж хийлгэх
	ГШҮ 4.4 Технологи ажиллагаанд дадлагажуулах
	ГШҮ 4.5 Гүйцэтгэлд хяналт тавих

Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага

ТҮВШИН VI
Чадамжийн нэгж: Үржлийн ажлыг зохион байгуулах
Чадамжийн нэгжийн код:
Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага
Эзэмшвэл зохих мэдлэг <ul style="list-style-type: none">• Гахайны үүлдэр, удам гарвал, эдгээрийн онцлог• Үүлдэр хоорондын эрлийзжүүлэлтийн хувилбар• Гахайн удамшил• Хээлтүүлэг хийх арга технологи, зохиомол/бодонгоор• Мэгжний орооны үед илрэх шинж тэмдэг• Гахайн өвчлөл, ерөнхий шинж тэмдэг• Худалдан авах ажиллагааны журам• Гахай тээвэрлэх, ачиж, буулгахад тавигдах шаардлага• Үржлийн сүргийн байрны хэм, тэжээлийн найрлага, бусад шаардлагууд
Эзэмшвэл зохих ур чадвар <ul style="list-style-type: none">• Гахайн үржил, ашиг шимийн үзүүлэлтүүдийг тодорхойлох• Халдвартай, халдваргүй өвчний ерөнхий шинж тэмдгээр оношлох• Мал зүйн үзлэг хийх, үнэлгээ хийх• Мал эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх• Үржлийн сүргийг бүртгэлжүүлэх• Хээлтүүлгийг зохион байгуулах• Бодонгийн үрийн шингэний чанарыг үнэлэх• Шаардлага хангасан үрийг хадгалах, ашиглах• Мэгжний ороог илрүүлэх, идэвхжүүлэх• Гахайг барьж, тавих эв дүйтэй байх• Бүтээгдэхүүний чанарыг үнэлэх• Удмын бичиг унших• Гадаад хэлний мэдлэгтэй байх• Төлөвлөх, тооцоолон бодох• Цаг хуваарилах• Мэдээлэл хайх, боловсруулах• Амьтан ачиж, буулгах, тээвэрлэхэд бэлтгэх• Амьдрах орчныг үнэлэх• Үржлийн гахайг стандарт шаардлагын дагуу байрлуулах• Өөхний зузаан хэмжих• Ээмэглэх, чихэнд ухам болон шивүүр номер хийх• Багаж тоног төхөөрөмжийг ажиллуулах
Хөдөлмөр эрхлэхэд зайлшгүй шаардлагатай хандлага, төлөвшил <ul style="list-style-type: none">• Амьтны эрүүл аюулгүй байдалд анхаарч ажиллах• Нягт нямбай, хариуцлагатай• Цагийн хуваарийг баримталдаг• Амгалан тайван, ажигч гярхай• Үнэнч шударга• Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах

Элемент, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт

ЭЛЕМЕНТ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
ЧЭ 1. Үржлийн сүргийг бүрдүүлэх	ГШҮ 1.1 Үржлийн сүрэг бүрдүүлэх төлөвлөгөө боловсруулах
	ГШҮ 1.2 Үржлийн сүргийг сонгох
	ГШҮ 1.3 Үржлийн сүргийг худалдан авах
	ГШҮ 1.4. Үржлийн сүргийг тээвэрлэх
	ГШҮ 1.5 Үржлийн сүргийг хүлээн авах
ЧЭ 2. Үржлийн сүргийг бүртгэлжүүлэх	ГШҮ 2.1 Гахайн эцэг эхийн гарвал, удам судрын бүртгэл хийх
	ГШҮ 2.2 Шаардлагатай багаж хэрэгслийг худалдан авах
	ГШҮ 2.3 Багаж, тоног төхөөрөмжийг байрлуулах.
	ГШҮ 2.4 Үржлийн сүргийг бүртгэх
ЧЭ 3. Хээлтүүлгийн тохироо хийх	ГШҮ 3.1 Үржлийн бүдүүвчийн дагуу бодонгийн гарвал, удам, ашиг шимийг тодорхойлох
	ГШҮ 3.2 Ямар үүлдэр, удмын мэгжийг ямар үүлдэр удмын бодонтой нийлүүлэх тохироо хийх
	ГШҮ 3.3 Үр төлөөс үржлийн сүрэгт сонгох
	ГШҮ 3.4 Үржлийн ажлын тохирооны дүнг хэлэлцэх
ЧЭ 4. Хээлтүүлгийн төлөвлөгөө боловсруулах	ГШҮ 4.1 Аж ахуйн жилийн нэгдсэн төлөвлөгөө боловсруулах
	ГШҮ 4.2 Үржлийн зориулалтаар борлуулах гахайн тоог сар, жилээр гаргах
	ГШҮ 4.3 Маханд борлуулах гахайн тоог сар, жилээр гаргах
	ГШҮ 4.4 Хээлтүүлгийг ямар аргаар хийхийг тодорхойлох
	ГШҮ 4.5 Хээлтүүлгийн төлөвлөгөөний үр дүнг хэлэлцэх
ЧЭ 5. Мэгжний ороог илрүүлэх	ГШҮ 5.1 Анхны нийлүүлэгт ашиглах хугацааг тогтоох
	ГШҮ 5.2 Мэгжний ороо илрэхэд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох
	ГШҮ 5.3 Мэгжний ороо саатахыг илрүүлэх
	ГШҮ 5.4 Мэгжний ороог идэвхжүүлэх
	ГШҮ 5.5 Ороо нь илэрсэн мэгжийг хээлтүүлэгт оруулах
ЧЭ 6. Бодонгийн үрийн чанарыг үнэлэх	ГШҮ 6.1 Бодонгоо бэлтгэх
	ГШҮ 6.2 Үр авах сав бэлтгэх
	ГШҮ 6.3 Үр гадагшлуулахад идэвхжүүлэх
	ГШҮ 6.4 Үр авахад бэлтгэх
	ГШҮ 6.5 Бодонгийн үрийг технологийн дагуу авах
	ГШҮ 6.6 Авсан үрийг шинжлэх
	ГШҮ 6.7 Шаардлага хангасан үрийг савлаж, бүртгэх
ЧЭ 7. Үржлийн сүргийг хээлтүүлэх	ГШҮ 7.1 Мэгжний ороог шалгах
	ГШҮ 7.2 Ороо орсон мэгжийг хээлтүүлэгт бэлтгэх
	ГШҮ 7.3 Бодонг хээлтүүлэгт бэлтгэх
	ГШҮ 7.4 Хээлтүүлгийг явуулах

	ГШҮ 7.5 Хээлтүүлгийн дараа бодонг хайснаас гаргах
	ГШҮ 7.6 Хээлтүүлгийг ажлыг 3 удаа давтан явуулах, бүртгэх
	ГШҮ 7.7 3 дахь удаагийн хээлтүүлгийн дараа мэгжийг хайсанд нь шилжүүлэх, бүртгэх
ЧЭ 8. Мэгжний хээлийг шалгах	ГШҮ 8.1 Хээлтүүлэгт оруулсан мэгжний жагсаалтыг үзэх
	ГШҮ 8.2 Хээлтүүлэгт оруулсанаар хойш 21, 42 хоносон мэгжний ороог мэдрэхүйгээр шалгах
	ГШҮ 8.3 Хээлтүүлэгт оруулсанаас хойш 21 хоног хоносон мэгжийг хээл тодорхойлох үзлэгт хамруулах. /Эхо аппаратаар/
	ГШҮ 8.4 Хээлтсэн мэгжийг хээлтэй мэгжний групп хайсанд оруулах
	ГШҮ 8.5 21, 42 хоногийн хугацаанд хээлтээгүй мэгжийг дахин хээлтүүлэгт оруулах
	ГШҮ 8.6 Хээлтүүлгийн бүртгэл хөтлөлтийг хөтлөх
ЧЭ 9. Үржлийн сүрэгт ангилалт хийх	ГШҮ 9.1 Үржлийн сүрэгт ангилалт хийх бэлтгэл хангах
	ГШҮ 9.2 Үржлийн сүрэгт ангилалт, заазлалт явуулах төлөвлөгөө боловсруулах
	ГШҮ 9.3 Үржлийн сүрэгт аж ахуйн журмын дагуу ангилалт хийх
	ГШҮ 9.4 Ангилалт, заазлалт явуулсан тухай тайлагнах
	ГШҮ 9.5 Ангилалт, заазлалтын үр дүнгээс үндэслэн цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх

Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага

ТҮВШИН VI
Чадамжийн нэгж: Гахайн сүргийг маллах
Чадамжийн нэгжийн код:
Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага
Эзэмшвэл зохих мэдлэг <ul style="list-style-type: none">• Гахайн биеийн бүтэц• Гахайн бүх төрлийн байр, зогсоолын орчны гэрэлтүүлэг, агаарын чанар, дулааны хэмийн стандарт шаардлагууд /нас, хүйс, төрлөөр/• Бүх төрлийн гахайн услах технологи, усны стандарт• Гахайны үржүүлэг• Бүх төрлийн гахайг тэжээх технологи• Бүх төрлийн гахайны хөдөлгөх болон амраах горим• Үржлийн гахайн нийлүүлгийн тохироо, төлөвлөгөө• Ариутгалын бодисууд, ашиглах заавар• Мал үржлийн болон мал эмнэлгийн багаж хэрэгсэлтэй ажиллах заавар, журам
Эзэмшвэл зохих ур чадвар <ul style="list-style-type: none">• Тэжээл бэлтгэх, ангилах, ялгах• Тэжээлийн норм тогтоох• Автомат тэжээл түгээгүүрийг ажиллуулах• Мэгж төллүүлэх• Ариутгалын бодисыг ашиглах• Газар зүйн байдлыг ялган таних• Гахайн эрүүл мэнд болон маллагааны стратегийг уялдуулан төлөвлөх, зохицуулах• Бусадтай харилцах• Унших, тооцоолох, бичих• Төлөвлөх, хяналт үнэлгээ хийх, дүгнэлт гаргах, тайлагнах,• Асуудал шийдвэрлэх, тодруулах, зөвшилцөх• Амьтантай эв дүйтэй харьцах• Төллөх мэгжний шинжийг таних• Төрөх мэгжид мал эмнэлгийн анхан шатны үзлэг хийх• Эх барих ажилбарын багажийг ажиллуулах• Торойг амлуулах, мал эмнэлгийн үзлэг хийх
Хөдөлмөр эрхлэхэд зайлшгүй шаардлагатай хандлага, төлөвшил <ul style="list-style-type: none">• Нягт нямбай• Гүйцэтгэл сайтай ажиллах• Хариуцлагатай• Багаар ажиллах• ХАБЭА шаардлагыг хангаж ажиллах• Амьтны эрүүл аюулгүй байдалд анхаарч ажиллах• Цагийн хуваарийг нягт баримтлах• Элгэмсэг• Амгалан тайван, ажигч гярхай

Элемент, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт

ЭЛЕМЕНТ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
ЧЭ 1. Гахайны байрны стандартыг шалгах	ГШҮ 1.1 Бүх төрлийн гахайн байрны гэрэлтүүлэг шаардлага хангаж байгаа эсэхэд хяналт тавих
	ГШҮ 1.2 Гахайн байрны агааржуулалтад хяналт тавих
	ГШҮ 1.3 Гахайн байрны усжуулалтын шугмын хэвийн ажиллагаанд хяналт тавих
	ГШҮ 1.4 Нэгж гахайны эзлэх орон зай стандартад нийцсэн эсэхийг төрөл тус бүрийн стандартын дагуу шалгах
	ГШҮ 1.5 Тэжээлийн онгоцны тохиромжтой байгаа эсэхийг шалгах
	ГШҮ 1.6 Гахайн байрны дулааны хэм стандарт шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгах
ЧЭ 2. Гахайн сүрэгт эрүүл мэндийн үзлэг хийх	ГШҮ 2.1 Бүх төрлийн гахайны бэртэл гэмтэл авсан эсэхийг шалгах
	ГШҮ 2.2 Гахайны зан араншинд өөрчлөлт гарсан эсэхийг нягтлах
	ГШҮ 2.3 Баас шээсний өнгийг ажиглах
	ГШҮ 2.4 Гадна бэлэг эрхтний хэвийн байдлыг ажиглах
	ГШҮ 2.5 Оношлогоог баталгаажуулах
ЧЭ 3. Бүх төрлийн гахайн усалгаанд хяналт тавих	ГШҮ 3.1 Бүх төрлийн гахайны усны хангамжийг шалгах
	ГШҮ 3.2 Усны хэм стандарт шаардлагад нийцсэн эсэх хяналт тавих
	ГШҮ 3.3 Усны эрүүл ахуйд хяналт тавих
	ГШҮ 3.5 Ус түгээгүүрийн эрүүл ахуй, хэвийн ажиллагааг шалгах
ЧЭ 4. Гахай тэжээх хөтөлбөрийг хэрэгжүүлэх	ГШҮ 4.1 Гахайн төрөл тус бүрээр тэжээх хөтөлбөр боловсруулах
	ГШҮ 4.2 Ажилтнуудад гахай тэжээх хөтөлбөрийг хэрэгжүүлэх зааварчилгаа өгөх
	ГШҮ 4.3 Гахай тэжээх хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих
	ГШҮ 4.4 Тэжээлийн чанар, эрүүл ахуйд хяналт тавих
	ГШҮ 4.5 Тэжээл түгээгүүрийн хүрэлцээтэй байдал, хэвийн ажиллагааг шалгах
ЧЭ 5. Гахайн байрны эрүүл ахуйг хянах	ГШҮ 5.1 Бүх төрлийн гахайн байрыг цэвэрлэх технологи зааварчилгаа өгөх
	ГШҮ 5.2 Цэвэрлэгээг технологийн дагуу гүйцэтгэж байгаа эсэхийг шалгах
	ГШҮ 5.3 Бүх төрлийн гахайны хэвтэр тогтмол хуурай байгаа эсэхэд хяналт тавих
	ГШҮ 5.4 ХАБЭА шаардлага мөрдөж байгаад хяналт тавих

ЧЭ 6. Гахайн сүргийг хөдөлгөх	ГШҮ 6.1 Бүх төрлийн гахайд тохирсон хөдөлгөөн хийлгэх зааварчилгаа боловсруулах
	ГШҮ 6.2 Гахайн сүргийг хөдөлгөх технологийн зааварчилгааг ажилтнуудад өгөх
	ГШҮ 6.3 Гахайн сүргийг хөдөлгөх хуваарийг гахайны төрөл тус бүрээр нь гаргах
	ГШҮ 6.4 Гахайг хөдөлгөхөд хяналт тавих
ЧЭ 7. Гахайн сүргийг амраах	ГШҮ 7.1 Гахайны төрөл тус бүрээр амрах горимыг боловсруулах
	ГШҮ 7.2 Гахайн төрөл тус бүрээр амраах хуваарийг гаргах
	ГШҮ 7.3 Гахайны амрах тав тухтай орчинг бүрдүүлэх
	ГШҮ 7.4 Гахайг амраах технологийн зааврыг ажилтнуудад өгөх
	ГШҮ 7.5 Гахайг амраах хуваарийн хэрэгжилтэд хяналт тавих
ЧЭ 8. Хээлтэй мэгжийг төллүүлэх	ГШҮ 8.1 Мэгжийг төллүүлэх орчин, нөхцөлийг бүрдүүлэх
	ГШҮ 8.2 Мэгжийг төллөлтөнд бэлтгэх
	ГШҮ 8.3 Хээлтэй мэгжийг төллүүлэх
	ГШҮ 8.4 Мал эмнэлгийн анхны тусламж үзүүлэх
	ГШҮ 8.5 Төллөсөн мэгжийг арчлах
	ГШҮ 8.6 Торойг амлуулах
	ГШҮ 8.7 Байр, орчныг цэвэрлэх

Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага

ТҮВШИН VI
Чадамжийн нэгж: Гахайн эрүүл мэндийг хамгаалах
Чадамжийн нэгжийн код:
Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага
Эзэмшвэл зохих мэдлэг <ul style="list-style-type: none">• Гахайн халдварт, паразиттах халдваргүй өвчин, хил дамжин халдварладаг өвчин• Мал, амьтны өвчнүүдтэй тэмцэх зааврууд• Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллага (ДМАЭМБ)-ын халдварт өвчинтэй тэмцэх журам• Гахайн үүлдрүүд• Гахайн биеийн бүтцийн онцлог, гахайн хэвийн физиологи• Гахайн эрхтэн тогтолцооны үйл ажиллагаа, хоорондын уялдаа холбоо• Гахайн эмчилгээ, арчилгаа маллагаа, тэжээл, тэжээллэг• Гахайны дархлааны тухай ойлголт• Эмийн бодисын үйлдлийн механизм• Гахайн аж ахуйн ариун цэврийн бүсийн бүтэц, зохион байгуулалт, тавигдах шаардлагууд• Гахайн аж ахуйд тавигддаг ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага• Ариутгал, халдваргүйжүүлэлтийн ач холбогдол• Ариутгал, халдваргүйжүүлэлтын ангилал, аргууд, халдваргүйжүүлэх үеийн хөдөлмөр хамгааллын заавар• Халдваргүйжүүлэх бодисын тун хэмжээ, үйлчлэгч бодис, үйлчилгээний механизм• Вакцин, түүний төрөл, дархлаажуулалтын ач холбогдол, анхаарах зүйл• Вакцин, туулгалтын бодис тээвэрлэх, хадгалах журам (Вакцин тээвэрлэх хэлхээ)• Туулгалтын бэлдмэл, түүний үйлчлэгч бодис, үйлчилгээний механизм• Багаж тоног төхөөрөмжийг зааврын дагуу ажиллуулах• Гахайн байрны агааржуулалтын системийн стандарт• Гахайн тав тухтай амьдрах орчны стандартууд• Мэгж төллөх үеийн физиологийн онцлог• Эрсдэлийн тухай ойлголт• Мэдээллийн сангийн бүтэц, ач холбогдол
Эзэмшвэл зохих ур чадвар <ul style="list-style-type: none">• Гахайн өвчнийг ялгаварлан оношлох• Гахайн байрны ариун цэврийн шинжилгээ хийх• Түгээмэл хэрэглэгддэг, сонгомол тэжээлт орчин бэлтгэх, ариутгах• Байрны дотоод орчны дээж авах• Халдваргүйжүүлэлт хийх• Вакциныг тээвэрлэх, хадгалах• Багаж тоног төхөөрөмжийг зааврын дагуу ажиллуулах• Бүх төрлийн бүртгэл хөтлөх• Тоон боловсруулалт хийх

<ul style="list-style-type: none"> • Microsoft office Word Excel програмууд дээр ажиллах <p>Хөдөлмөр эрхлэхэд зайлшгүй шаардлагатай хандлага, төлөвшил</p> <ul style="list-style-type: none"> • Нягт нямбай • Гүйцэтгэл сайтай ажиллах • Хариуцлагатай • Ажилсаг • Хичээнгүй • Дүрэм журмыг чанд дагаж мөрдөж ажилладаг • Багаар ажиллах • ХАБЭА шаардлагыг хангаж ажиллах
--

Элемент, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт

ЭЛЕМЕНТ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
ЧЭ 1. Мал эмнэлэгийн ариун цэврийн бүс байгуулах	ГШҮ 1.1 Гахайн аж ахуйн ариун цэврийн бүсийн байгуулалтыг төлөвлөх
	ГШҮ 1.2 Гахайн аж ахуйг гадаад орчноос хязгаарлах хашаа бариулах
	ГШҮ 1.3 Аж ахуйд нэвтрэх хорио цээрийн нэвтрэх цэг байгуулах
	ГШҮ 1.4 Аж ахуйд нэвтрэх ариутгал, халдваргүйжүүлэлтийн мэдээллийн сан байгуулах
	ГШҮ 1.5 Гахайн аж ахуйн ариун цэврийн бүсийн үйл ажиллагаанд хяналт тавих
ЧЭ 2. Аж ахуйн орчныг халдваргүйжүүлэх	ГШҮ 2.1 Гахайн аж ахуйн халдваргүйжүүлэлтийн төлөвлөгөө боловсруулах
	ГШҮ 2.2 Гахайн аж ахуйд гадаад орчны механик цэвэрлэгээ хийх
	ГШҮ 2.3 Гахайн аж ахуйн гадаад орчинд урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт хийх
	ГШҮ 2.4 Шаардлагатай тохиолдолд гахайн аж ахуйн гадаад орчинд зориудын халдваргүйжүүлэлт хийх
	ГШҮ 2.5 Гахайн аж ахуйн байрыг халдваргүйжүүлэлтэд бэлтгэх
	ГШҮ 2.6 Гахайн аж ахуйн байранд урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт хийх
	ГШҮ 2.7 Шаардлагатай тохиолдолд гахайн аж ахуйн байранд зориудын халдваргүйжүүлэлт хийх
ЧЭ 3. Вакцинжуулалтын ажлыг зохион байгуулах	ГШҮ 3.1 Гахайн сүрэгт товлолтын болон товлолтын бус вакцинжуулалт хийх төлөвлөгөө боловсруулах
	ГШҮ 3.2 Вакцин хадгалах зориулалтын орчныг шаардлагад нийцүүлэн бэлтгэх
	ГШҮ 3.3 Товлолтын вакциныг бэлтгэх

	ГШҮ 3.4 Товлолтын бус вакцинжуулалтын мэдээлэл бэлтгэх
	ГШҮ 3.5 Вакцинжуулалтын бүртгэлийн мэдээллийн сан байгуулах
ЧЭ 4. Туулгалтын ажлыг зохион байгуулах	ГШҮ 4.1 Гахайн сүрэгт туулгалт хийх төлөвлөгөө боловсруулах
	ГШҮ 4.2 Туулгалтын бэлдмэл хадгалах зориулалтын орчныг шаардлагад нийцүүлэн бэлтгэх
	ГШҮ 4.3 Туулгалтын бэлдмэлийг бэлэн байлгах
	ГШҮ 4.4 Туулгалтын бүртгэлийн мэдээллийн санг байгуулах
ЧЭ 5. Сүргийг мал эмнэлэгийн үзлэгт хамруулах	ГШҮ 5.1 Сүргийн эрүүл мэндийн байдлыг үнэлэх
